

1

СТРАТЕГИ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

№	Стратеги төлөвлөгөө болон ундэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин / Биелэлт	Гүйцэтгэлийн хувь
Яамны стратеги зорилт 1. Харилцаа холбоо, инновац, гарааны бизнес, их өгөгдөл, хиймэл оюун, мэдээллийн технологи, шуудан, өргөн нэвтрүүлэг, радио давтамж, сансарын технологи, кибер аюулгүй байдлыг хангах хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, урт болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө боловсруулах, шаардагдах судалгаа шинжилгээ хийх, хөгжлийн бодлогын уялдааг хангах бодлогын удирдамжаар хангах, хууль эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх.						
	Зорилт 1. Харилцаа холбоо, шуудан, өргөн нэвтрүүлгийн хөгжлийн бодлого, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангана.	Хүргүүлсэн баримт бичгийн тоо Баталсан баримт бичгийн тоо	-	4 4	Хүргүүлсэн баримт бичгийн тоо 4 Арга хэмжээний тоо 4	80
1.	Арга хэмжээ 1.1. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.	Хүргүүлсэн хуулийн төслийн тоо	-	1	Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төслийг боловсруулсан. Хуулийн төсөл боловсруулахтай холбогдуулан БНСУ-ын Цахилгаан холбооны эрх зүйн байдлыг зохицуулсан хуулиудыг судалсан.	50

	Арга хэмжээ 1.2. Шуудангийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.	Хүргүүлсэн хуулийн төслийн тоо	-	1	Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой санал боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг ЦХИХХ-ны сайдын 2025 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн А/73 дугаартай тушаалаар байгуулсан. Тус ажлын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдөр болон 05 дугаар сарын 16-ны өдрүүдэд Улсын Их Хурлын Инновац цахим бодлогын байнгын хороонд Шуудангийн тухай хуулийн хэрэгжилт болон тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар мэдээлэл хийсэн. Мөн шуудангийн үйлчилгээ үзүүлэгч оролцогч талуудаас хуулийн нэмэлт өөрчлөлтөд оруулах санал болон Шуудан, цахим худалдааны бодлого, зохицуулалтын үйл ажиллагаанд тусгах санал авахаар шуудангийн үйлчилгээ үзүүлэгч 24 байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 01/1278 дугаартай албан бичиг хүргүүлэн саналыг хүлээн авч ажиллаж байна.	100
2.						

	Арга хэмжээ 1.3 Дэлхийн шуудан холбооны дүрмийн 11 дүгээр нэмэлт протоколыг соёрхон батлахтай холбоотой материалыг боловсруулан Засгийн газарт хүргүүлнэ.	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	-	1	Дэлхийн шуудан холбооны дүрмийн 11 дүгээр нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан нийт 20 байгууллагын саналыг авч нэгтгэсэн. Мөн Гадаад харилцааны яам, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яамдаас хэлэлцүүлэх зөвшөөрлийг авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулан Гадаад харилцааны сайдаар батлуулсан, Хууль зүй дотоод хэргийн сайдаар батлуулахаар хүргүүлсэн боловч тус хуулийн холбогдох судалгааг боловсруулан ирүүлэх хүсэлтийн дагуу хуулийн төслийг батлуулахад шаардагдах судалгааг боловсруулан ажиллаж байна.	70
4.	Арга хэмжээ 1.4. Хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн технологи нэвтэрч байгаатай холбогдуулан 2G, 3G технологид сууринласан сүлжээ, үйлчилгээний өнөөгийн байдлын судалгааг хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн A/45 дугаар тушаалаар батлуулсан.	Батлуулсан баримт бичгийн тоо	-	1	1.Хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн технологи нэвтэрч байгаатай холбогдуулан 2G, 3G технологид сууринласан сүлжээ, үйлчилгээний өнөөгийн байдлын судалгааг хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн A/45 дугаар тушаалаар батлуулсан. 2.Ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу судалгааны асуулгыг боловсруулж, асуулгын хүрээнд 2G болон 3G сүлжээний өнөөгийн байдлын судалгааг хот, аймаг, сум, суурин газрын түвшинд хийж, санал дүгнэлт боловсруулсан.	100

					3. Судалгаанд үндэслэн хөдөлгөөнт холбооны 2G болон 3G сүлжээг зогсооход баримтлах чиглэлийн төсөл боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авч байна.	
5.	Арга хэмжээ 1.5. Нам орбитын хиймэл дагуулын сүлжээ ашиглахад баримтлах бодлогын чиглэлийн төсөл боловсруулна.	Боловсруулсан төслийн тоо	-	1	<p>Нам орбитын хиймэл дагуулын сүлжээ ашиглах талаар судалгаа хийж, холбогдох баримтлах чиглэлийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллах албан хаагчдын мэдээллийг авахаар 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 02/1153 дугаар бүхий албан бичгийг 16 байгууллагад хүргүүлж, улмаар Ажлын хэсгийн тушаалын төслийг боловсруулсан.</p> <p>Тайлант хугацаа болоогүй</p>	-
	Зорилт 2. Цахим засаглалын хөгжлийн бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангана	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	-	5	Хүргүүлсэн баримт бичгийн тоо-5	100
7.	Арга хэмжээ 2.3. Төрийн байгууллагын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг үе шаттайгаар цахимжуулна.	Цахим хэлбэрт шилжүүлсэн зөвшөөрлийн тоо	-	1	<p>Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэхтэй холбоотой өнөөгийн нөхцөл байдлын талаар танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг ЗГХЭГ-ын Цахим засаглалын хэлтсийн дарга Б.Билэгдэмбэрэлтэй хамтран боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хуралдаанд танилцуулсан ба Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 14 дүгээр тэмдэглэлээр “Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хөнгөвчлөх, цахим хэлбэрт шилжүүлэх,</p>	100

					холбогдох захиргааны хэм хэмжээний актуудыг хуульд нийцүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Засгийн газрын холбогдох гишүүд, албан тушаалтанд үүрэг даалгавар өгөгдсөн. Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлснээр 2025 оны II улирлын байдлаар "license.mn"-ээр 76, "e-business.mn"-ээр 44, эрх бүхий байгууллага өөрийн системээр 123, уламжлалт буюу цаасан хэлбэрээр 16 тусгай зөвшөөрлийг олгож, зөвшөөрлийн нэгдсэн санд 151746 нэгж зөвшөөрлийн мэдээлэл бүртгэгдээд байна.	
8.	Арга хэмжээ 2.4. Нотариатын үйл ажиллагааг үе шаттай сайжруулна.	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	-	1	"Төр, хувийн хэвшилийн үйл ажиллагаанд цахим гэрээг нэвтрүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх (нотариат) судалгаа" ЦХИХХЯ/20250203039 дугаартай төслийн ажлыг даалгавар болон тус тендерийг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороо байгуулах тушаалын төслийг тус тус боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын "Үнэлгээний хороо байгуулж, зардал гаргах тухай" 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/146 дугаар тушаал батлагдсан.	100
	Зорилт 3. Инновац, гарцааны бизнес, их өгөгдөл, хиймэл оюун хөгжлийн бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангана.	Хүргүүлсэн баримт бичгийн тоо Боловсруулсан баримт бичгийн тоо Зохион байгуулсан арга хэмжээ	- 4 2	0	Хүргүүлсэн баримт бичгийн тоо-1 Боловсруулсан баримт бичгийн тоо-4 Зохион байгуулсан арга хэмжээ-2	100

9.	Арга хэмжээ 3.1. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн тухай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын урьдчилан тандан судалгаа хийх, хуулийн төсөл боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	-	1	Хариуцсан мэргэжилтэн байхгүй. Инновацын бодлого зохицуулалтын газар хариуцаж буй болно.	-
10.	Арга хэмжээ 3.2. Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулна.	Батлуулсан журмын тоо	Мэдээллийн технологийн үйлдвэр лэлийг дэмжих тухай хууль	1	Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн баримт бичиг болон урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан, Засгийн газрын 2020 оны 100 дугаар тогтоолоор баталсан Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу “Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-ний анхны төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн, 5 зорилтын хүрээнд 37 ажил, арга хэмжээ хэрэгжүүлэх стратегийн төслийг, стратегийн зорилтын шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, суурь болон зорилтот түшингийн хамт эцэслэн боловсруулж, Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 03 дугаар тогтоолоор “Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги” төлөвлөгөө батлагдсан.	100

11.	Арга хэмжээ 3.3. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу бүсүүдэд, Бүсийн цахим шилжилт, өндөр технологи нэвтрүүлэлт” сэдэвт салбар хуралдааныг зохион байгуулна.	Зохион байгуулсан зөвлөгөөний тоо	-	1	<p>Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааны үеэр бүсийн цахим шилжилт, өндөр технологи нэвтрүүлэлтийн салбар хуралдааныг яамны эрхлэх асуудлын хүрээнд:</p> <p>1. Салбарын зорилтыг бүсийн хөгжилтэй уялдуулан бүс, орон нутагт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 5 мега төслийн саналыг хүsnэgтийн дагуу боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01/941 дугаартай албан бичгээр Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд хүргүүлэв.</p> <p>2. Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанд модератор, панилестаар оролцох албан тушаалтнуудын нэrsийн жагсаалтыг холбогдох мэдээллийн хамт гарган 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Орон нутаг, салбарын хөгжлийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн Г.Энхболорт хүргүүлэв.</p> <p>3. Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан модератор, панелистаар оролцох албан тушаалтнууд болон хуралдаан зохион байгуулах ажлын хэсэг, хурлын протокол хөтлөх албан хаагчдад зааварчилгаа өгөх, хурлын агуулга, чиглүүлэх асуулт тохиорх нэгдсэн уулзалтад оролцов. Уулзалт 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр Блю Скай зочид буудлын Эмералд танхимд зохион байгуулагдсан.</p> <p>4. “Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан-2025” бүсийн салбар хуралдааны хэлэлцүүлгийн агуулгыг загвар хүsnэgтийн дагуу боловсруулан ажлын хэсгийн ахлагч Ш.Батзаяатад танилцуулж, бүсчилсэн хөгжлийн бодлогын хэрэгжилтийн газрын Инновац</p>	100
-----	---	-----------------------------------	---	---	--	-----

					дамжуулалтын хэлтсийн дарга М.Баярт 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр хүргүүлэв. 5.“Хангайн, Хойд, Говийн бүсийн өргөтгөсөн хуралдаанд оролцох албан тушаалтны” томилолтын тушаалыг боловсруулан Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн А/86 тушаалаар, 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн А/107 тушаалаар, 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн тушаалаар тус тус батлуулав. 6.“Говийн болон Төвийн бүсийн хөгжлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулан 2025 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 01/1186 дугаартай, 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 01/1324 дугаартай албан бичгээр Монгол Улсын шадар сайд С.Амарсайханд хүргүүлэв.	
	Зорилт 4. Салбарын урт, дунд болон богино хугацааны стратегийн төлөвлөгөө боловсруулна	Хүргүүлсэн баримт бичгийн тоо Боловсруулсан баримт бичгийн тоо	2	2	Хүргүүлсэн баримт бичгийн тоо-2 Боловсруулсан баримт бичгийн тоо-2	100
12.	Арга хэмжээ 4.1. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн төсөлд тусгуулах төсөл арга хэмжээний тооцоолол хийж, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлнэ.	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	-	1	Монгол Улсын тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын “Аргачлал, заавар батлах тухай” 2025 оны А/08 дугаар тушаалын III дугаар хавсралтаар батлагдсан “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах цаглавар”-ын дагуу тус ажил 06 дугаар сарын 15-ны өдрөөс хэрэгжиж эхэлнэ. Мөн Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангахад чиглэгдсэн,	-

					нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулна.” гэсэн шаардлагыг хангах төсөл байхгүй байна.	
13.	Арга хэмжээ 4.2. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд тусгуулах төсөл, арга хэмжээний тооцоолол хийж, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлнэ.	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	-	1	<p>Тус яамнаас 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/98 дугаартай албан бичгээр Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгуулах нийт 13 төслийн саналыг Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж, 6 төсөл, арга хэмжээ дэмжигдсэний дагуу ЭЗХЯ-ны Хөгжлийн нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга Ц.Эрдэнэбат болон холбогдох албаны хүмүүстэй 2025 оны 3 дугаар сарын 11, 17-ний өдрүүдэд тус тус уулзалт зохион байгуулж, хиймэл оюун, инновацийг дэмжих чиглэлээр 3 төсөл, арга хэмжээг нэмж тусгасан. Мөн Сангийн яамнаас дээр дурдсан 6 төслийг хасах санал гаргасны дагуу холбогдох тайлбар, мэдээллийг нэгтгэн боловсруулж ЭЗХЯ-нд хүргүүлсэн.</p> <p>Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэлд үндэслэн тус яамнаас хариуцан хэрэгжүүлэх нийт 25 төсөл (өмнө дэмжигдсэн 6 төсөл багтсан)-ийн төслийн саналыг шалгуур үзүүлэлт, тайлбарын хамт нэгтгэн боловсруулж, 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 01/916 дугаартай албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн ба Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар</p>	100

					"Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө" батлагдсан.	
14.	Арга хэмжээ 4.3. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2024-2028 оны стратеги төлөвлөгөө боловсруулж, батлуулна.	Батлуулсан баримт бичгийн тоо	-	1	<p>Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж, ЦХИХХ-ны сайдын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 05 дугаар тушаалаар батлуулсан. Стратеги төлөвлөгөөг боловсруулах хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн:</p> <p>1.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын өнөөгийн байдал, стратеги төлөвлөгөө боловсруулах хэрэгцээ шаардлага, мандатын шинжилгээ, орчны шинжилгээг хийж, зорилго зорилтуудыг тодорхойлсон.</p> <p>2.ЗГУАХ 2024-2028-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан төсөл, арга хэмжээ болон холбогдох нэгжүүдээс ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулсан.</p> <p>3.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлийн олон улсын индексүүдийн 2024 оны үзүүлэлтүүдийг судалж, зорилтод түвшнийг тодорхойлон холбогдох тайлбаруудыг оруулсан.</p> <p>4.2024 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр харьяа байгууллагын удирдлагуудад танилцуулж, холбогдох саналыг тусгасан.</p>	100
15	Арга хэмжээ 4.4. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2025 оны төлөвлөгөө боловсруулж, батлуулна.	Батлуулсан баримт бичгийн тоо	-	1	Яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахтай холбогдуулан ЗГУАХ 2024-2028, Яамны стратеги төлөвлөгөө 2024-2028, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Монгол улсын хөгжлийн төлөвлөгөө 2025,	100

					Яамны 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Газар, хэлтсүүдийн 2025 оны төлөвлөгөөний төслүүд зэрэг баримт бичгүүдээс төлөвлөгөөний төсөлд тусгах холбогдох төсөл, арга хэмжээнүүдийг нэгтгэн боловсруулж газрын дарга нарын хурлаар хэлэлцүүлж, 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр батлуулсан.	
Зорилт 5. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн хөгжил, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хүний нөөцийн бодлого боловсруулах, төлөвлөлт хийнэ.	Батлуулсан баримт бичгийн тоо Хөгжүүлж ажиллуулсан платформын тоо	-	4 1	Батлуулсан баримт бичгийн тоо-4 Хөгжүүлж ажиллуулсан платформын тоо-1		53.4
16. Арга хэмжээ 5.3. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн бодлогын баримтлах чиглэл боловсруулж, батлуулна.	Батлуулсан баримт бичгийн тоо	-	1	1.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа их дээд сургуулиудын удирдлагуудтай хамтран ажиллах, санал солилцох уулзалтыг зохион байгуулахаар 2025 оны 03/127 дугаартай албан бичгээр 23 их дээд сургуулиуд руу албан бичгээр хүргүүлэв. 2.Салбарын хүний нөөцийг сургахад тулгамдаж буй асуудал, тус яамнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар танилцуулж, их дээд сургуулиудын удирдлагууд болон багш нарын төлөөлүүдтэй санал солилцох уулзалтыг зохион байгуулав. Уулзалтад Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон		30

					<p>гүйцэтгэгч Ш.Батзаяат, Кибер аюулгүй байдлын бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Пүрэвням, Стратеги, бодлого, төлөвлөлтийн мэргэжилтэн Д.Сэлэнгэ болон их дээд сургуулиудын төлөөллүүд оролцов. Уулзалтыг 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр тус яамны Хүндэтгэлийн танхимд зохион байгуулсан.</p> <p>3. Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл шинэчлэн батлах" тухай Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01/858 дугаартай албан бичгээр Боловсролын яаманд хүргүүлэв.</p> <p>Тайлант хугацаа болоогүй</p>	
17.	Арга хэмжээ 5.4. Төрийн үйлчилгээг цахимаар авахад иргэдэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, иргэдийн цахим ур чадварыг тодорхойлох судалгаа хийх, зөвлөмж боловсруулна.	Судалгааны тоо	-	1	<p>1.“Төрийн үйлчилгээг цахимаар авахад иргэдэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, иргэдийн цахим ур чадварыг тодорхойлох судалгаа хийх, зөвлөмж боловсруулах” ажлын даалгаврыг боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулав.</p> <p>2.“Төрийн үйлчилгээг цахимаар худалдан авахад иргэдэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, иргэдийн цахим ур чадварыг тодорхойлох судалгаа хийх, зөвлөмж боловсруулах ажлын даалгаврыг боловсруулах” тэндээр шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий “Үнэлгээний хороо байгуулах, зардал гаргах тухай” тушаалын төслийг боловсруулж Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/118 тушаалаар батлуулав.</p>	30

					Тайлант хугацаа болоогүй	
18.	Арга хэмжээ 5.6 Их дээд сургуулиудад суралцаж буй оюутнуудыг дадлага хийхэд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллана.	Хамтран ажилласан байгууллагын тоо	-	3	<p>1.Мэдээлэл технологийн чиглэлээр III-IV күрст суралцаж буй оюутнуудыг харьяа болон салбарын байгууллагуудад мэргэжлийн чиглэлээр дадлага хийлгэх тал дээр хамтран ажиллахаар 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 01/357 дугаартай албан бичгээр 23 их дээд сургуулиудад хүргүүлэв.</p> <p>2.Их дээд сургуулиудын ХХМТ-ийн чиглэлээр суралцаж буй III-IV курсын оюутнуудыг дадлагад гаргахаар ирүүлсэн саналыг үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01/1161 дугаартай албан бичгээр дадлагад гарах оюутнуудын нээсний жагсаалтыг гарган харьяа болон салбарын байгууллагын дарга наарт хүргүүлэв.</p> <p>3.Үндэсний Батлан хамгаалах их сургууль, ШУТИС-МХТС, МУИС, Отгонтэнгэр их сургуулийн оюутнуудын дадлагын ажлыг эхлүүлээд байна.</p>	100%
	Зорилт 6. Харилцаа холбоо, мэдээлэл технологийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг эрчимжүүлж, судалгаа хөгжлийн нэгдсэн тогтолцоог бий болгох ажлыг зохион байгуулах, зохицуулна.	Судалгааны тоо Саналын тоо	5 2		Судалгааны тоо-5 Саналын тоо -2	100
19.	Арга хэмжээ 6.1. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр олон улсын байгууллагуудаас гаргадаг индексийн харилцан уялдааг судалж,	Санал, зөвлөмжийн тоо	-	1	“Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын олон улсын индексүүдийн түвшинг тодорхойлж, анализ хийх” ЦХИХХЯ/20250603061 дугаартай судалгааны ажлын даалгаврыг боловсруулж сонгон	100

	салбарын стратеги төлөвлөгөөнд тусгах санал, зөвлөмж боловсруулах.				шалгаруулалтыг явуулсан. Сонгон шалгарсан компанийтай Y/16 дугаартай гэрээ байгуулна улмаар судалгааны ажлыг хүлээн авсан.	
20	Арга хэмжээ 6.2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр шинээр боловсруулах болон шинэчлэх стандартад санал боловсруулж, хүргүүлнэ.	Саналын тоо	-	1	Хариуцсан албан хаагч томилогдоогүй тул тайлант хугацаанд үнэлэх боломжгүй	-
21	Арга хэмжээ 6.3. Цахим эдийн засгийн суурь судалгаа хийж, хэлэлцүүлэг зохион байгуулна.	Судалгааны тоо Хэлэлцүүлгийн тоо	- -	1 1	<p>Монгол Улсын дижитал эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох, бусад орны сайн жишгийн судалгаа хийх Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч, олон улсын сайн туршлагыг судлах үндсэн дээр дижитал эдийн засгийн суурь судалгааг хийж, өөрийн орны онцлогт нийцүүлэн хөгжүүлж өргөжүүлэх, үр дүнтэй стратеги боловсруулах зорилгоор “Дижитал эдийн засгийн суурь судалгаа хийж, хэлэлцүүлэг зохион байгуулах” ЦХИХХЯ/20250603059 дугаартай ажлын даалгаврыг боловсруулж батлуулсан. Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн A/136 дугаартай “Үнэлгээний хороог байгуулах, зардал гаргах тухай” тушаалаар батлуулсан. Тендер шалгаруулалтыг зарласан.</p> <p>Тайлант хугацаа болоогүй</p>	-
22	Арга хэмжээ 6.4. Тоон гарын үсгийн хэрэглээний	Судалгааны тоо Зөвлөмжийн тоо	- -	1 1	“Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа,	100

	судалгаа хийж, зөвлөмж боловсруулна.				ажил, үйлчилгээний төлөвлөгөө"-д туссан "Тоон гарын үсгийн хэрэглээний судалгаа хийж, зөвлөмж боловсруулах ЦХИХХЯ/20250603060" дугаартай тендер шалгаруулалтыг зохион байгуулж, 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 06/05 дугаартай албан бичгээр төслийн гүйцэтгэлийн эцсийн тайланг хүлээн авч, 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр гэрээг дүгнэн акт үйлдэж, баталгаажуулсан.	
23	Арга хэмжээ 6.5. Төрийн байгууллагуудад ашиглаж буй мэдээллийн технологийн шийдэл, системүүдийн нэгдсэн судалгаа хийж, зөвлөмж боловсруулна.	Судалгааны тоо Зөвлөмжийн тоо	- -	1 1	1. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбараас үзүүлж буй төрийн үйлчилгээг хувийн хэвшилд шилжүүлэн гүйцэтгүүлэх боломжтой санал авах тухай 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 03/1270 дугаартай албан бичгийг харьяа болон салбарын байгууллагад хүргүүлсэн. Мөн тус асуудлаар хувийн хэвшлийн байгууллагаас санал авах зорилгоор 2025 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр яамны фейсбүүк хуудсанд мэдээлэл оруулж, нийт 5 байгууллагаас санал ирүүлснийг нэгтгэсэн. 2. Тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн "Нийтийн мэдээллийн дэд бүтцийн өнөөгийн нэхцэл байдалд үнэлгээ хийх, зөвлөмж боловсруулах" ЦХИХХЯ/20250103058 төслийн ажлын даалгаварт "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээлэл хариуцагчийн ашиглаж байгаа, шинээр хөгжүүлж байгаа болон хөгжүүлэхээр төлөвлөсөн мэдээллийн систем, мэдээллийн сан, мэдээллийн	100

					сүлжээний нэгдсэн судалгааг сүүлийн 3 жилээр гаргаж, төсөвт өртөг болон давхардлыг тогтоох" гэсэн ажлыг тусгасан болно.	
	Зорилт 7. Салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход хуулийн давхардал, хийдэл, зэрчлийг арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах талаар зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	Хэрэгжилтийн хувь	-	100	Хэрэгжилтийн хувь-100%	68
24.	Арга хэмжээ 7.1. Захиргааны хэм хэмжээний актын салбарын нэгдсэн бүртгэл хөтлөх цахим системийг бий болгоно.	Системийн тоо	-	1	Тайлант хугацаа болоогүй.	-
25.	Арга хэмжээ 7.2. Захиргааны хэм хэмжээний актын тоог цөөрүүлэх, журмаар зохицуулах харилцааг холбогдох хуульд тусгах асуудлаар салбарт хамаарах Засгийн газрын тогтоолоор баталсан хэм хэмжээний актад хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн актын тоо	-	26	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар 17 хуульд захиргааны хэм хэмжээний акт батлах 49 эрх олгосон заалт туссанаас 35 заалтын хүрээнд захиргааны хэм хэмжээний актыг баталсан байна. Дээрх 35 акт тус бүрд хяналт шинжилгээ, үнэлгээг дараах 5 асуудлын хүрээнд хийж байна: 1.тэмдэглэх хэсэгт үндэслэл болгосон хуулиар тусгайлан эрх олгосон хуулийн заалтад өөрчлөлт орсон эсэх; 2.хавсралтаар баталсан журмын дотор үндэслэл болгож эшлэл хийсэн заалтууд болон бусад зохицуулалтууд нь шинээр батлагдсан хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх; 3.бүртгэлтэй шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулсан болон хүчингүй болгосон	50

					шийдвэрээ тухай бүрд нь ирүүлж сан холбогдох хөдөлгөөн хийсэн эсэх; 4.ач холбогдоо алдсан, дагаж мөрдөхгүй болсон шийдвэрийг сангаас хасуулах арга хэмжээ авсан эсэх; 5.улсын нэгдсэн санд бүртгүүлээгүй шийдвэр байгаа эсэх, хуульд нийцүүлэн бүртгүүлэх арга хэмжээг авсан эсэх.	
26	Арга хэмжээ 7.3. Хуулиар эрх олгосон захиргааны хэм хэмжээний актыг холбогдох албан хаагчидтай хамтран боловсруулна.	Арга зүйн зөвлөгөө үзүүлж хамтран ажилласан журмын тоо	59	15	<p>1.“Хөдөлмөрийн дотоод журам”, “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр”, “Ахмадын санг ажиллуулах журам”, “Албан томилолтын журам”, “Салбарын шагнал олгоход мөрдөх журам”-ын төслийг хэлтсийн албан хаагчдын хамт боловсруулан батлуулсан.</p> <p>2.Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан “Хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах журам”, “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам”, Мэдээллийн технологийн “Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд заасан “виртуал бүсийн ажиллах журам”, “Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам”, Инновацийн тухай хуульд заасан “Инновацийн төслийг улсын төсвөөс</p>	50

санхүүжүүлэх журам”, “Инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан “Төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагаас үйлчилгээ үзүүлэх журам”, Дэлхийн радио холбооны WRC23 хурлын шийдвэрийн дагуу Дэлхийн Радио холбооны дүрэм 2024 (ITU RR 2024)-ын нэмэлт, өөрчлөлтийг Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтийг шинэчлэн батлуулах ажилд холбогдох газар, хэлтсийн албан хаагчидтай хамтран ажилласан.

3.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9.2, 22.9.10, 22.9.11-т заасан харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын үйл ажиллагааг нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжих зорилгоор элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан хөрөнгө оруулалт, харилцан хамааралгүй бусад этгээдээс олгосон санхүүгийн дэмжлэг, хандивын зардлыг гаргасан ахуйн нэгж, байгууллагад хуульд заасан татварын хөнгөлөлт олгоход тавигдах шаардлагын төслийг боловсруулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/79 дүгээр тушаалаар батлуулсныг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 7258 дугаарт бүртгэсэн.

	Арга хэмжээ 7.4. Сайд, Төрийн нарийн бичгийн даргын шийдвэртэй холбогдох эрх зүйн маргааныг хууль, шүүхийн байгууллагаар хянан шийдвэрлэх ажиллагаанд байгууллагын эрх ашгийг хамгаалан оролцох.	Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон хэргийн тоо	4	1	1.Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/37 дугаар тушаалаар батлагдсан “Радио долгионы ашиглалт үйлчилгээний төлбөр тогтоо журам”-ын 2.2.8 дахь заалтыг хүчингүй болгуулах тухай Ондо ХХК-ын нэхэмжлэлтэй захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд шинжээч С.Онончимэгийн хамт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажилласан бөгөөд тус компани гаргасан нэхэмжлэлээсээ татгалзсаныг шүүх баталгаажуулж, хэргийг хэрэгсэхгүй болгох захирамж гаргасан. 2.Тус яаманд холбогдуулан Дүйнхэр тэргүүн ХХК-ийн нэхэмжлэлтэй Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гаргасан “Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Мэдэгдэл хүргүүлэх тухай” 03/1063 дугаартай албан бичгийг хүчингүй болгуулах”, шалгарсан багцад гэрээ байгуулахыг даалгах талаарх захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд мэргэжилтэн Г.Болорчимэгийн хамт итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажилласан. Шүүхээс 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн шийдвэрээр нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь ханган шийдвэрлэсэн бөгөөд давж заалдах гомдол гаргахаар ажиллаж байна.	100
27	Арга хэмжээ 7.5. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохтой	Хэлэлцүүлгийн тоо	-	1	Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийн дагуу салбарт мөрдэж байгаа зөвшөөрөлтэй холбоотой харилцааг зохицуулж байгаа салбарын	60
28						

				<p>холбоотой эрх зүйн орчны судалгаа хийж, холбогдох хууль, захиргааны хэм хэмжээний актад өөрчлөлт оруулах санал боловсруулах, саналыг олон нийтээр хэлэлцүүлэх.</p> <p>сайдаас баталсан 2, Харилцаа холбооны Зохицуулах хорооноос баталсан 44 актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж салбарын сайдаас баталсан 1 актыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/35 дугаар тушаалаар хүчингүй болгож, Цахим гарын үсгийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг тус тус боловсруулаад байна.</p> <p>Харилцаа холбооны Зохицуулах хорооноос баталсан 27 актыг хуулиар захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгогдоогүй, хуулиар олгосон эрхийг хэтрүүлсэн, Зөвшөөрлийн тухай хуулийг зөрчсөн, бизнес эрхлэгчдэд дарамт, тээг болсон шат дамжлага үүсгэсэн шинжтэй гэж үзэж зөрчилтэй актуудыг хуульд нийцүүлж, хүчингүй болгох арга хэмжээ авах талаар чиглэл хүргүүлсэн.</p> <p>Тус хорооноос 6 актыг бүхэлд нь, 8 актын 82 заалтыг тус тус хүчингүй болгосон талаар 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/289 дугаартай албан бичгээр мэдэгдээд байна.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон дагаж боловсруулсан тус салбарын 5 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Мэдээлэл холбооны операторуудын ассоциаци болон үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид, харьяа байгууллагуудын хуульч нар, яамны албан хаагчдаас санал авах /албаны цахим шуудангийн хэмжээнээс хэтэрсэн</p>
--	--	--	--	---

					тул/-аар 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр хүргүүлсэн. Харилцаа холбооны зохицуулах хороо, Мобиком корпораци ХХК, Юнител ХХК, Скайтэл ХХК, Ондо ХХК нараас санал ирүүлснийг нэгтгэн санал дээр яамны болон Зохицуулах хорооны албан хаагчидтай хамтран ажилласан. Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн өргөтгесөн хуралдаанаас гарсан дүгнэлтийн дагуу зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон болон зөвшөөрөл олгоход ач холбогдолгүй цаг хугацаа шаардсан, шат дамжлага үүсгэсэн баримт бичгийг хүчингүй болгох хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас боловсруулсан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон уг хуулийг дагаж боловсруулсан салбарт хамаарах хуулийн төслүүдэд Харилцаа холбооны Зохицуулах хороо болон салбарын үйлчилгээ эрхлэгчдээс ирүүлсэн саналыг нэгтгэн цахимаар 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр боловсруулсан нь сайдаас зөвшөөрөл олгож байгаа төлөвтэй байна.	
29	Арга хэмжээ 7.6. Яамны дотоод үйл ажиллагаанд дагаж мөрдөх журмын төсөл боловсруулна.	Боловсруулсан журмын тоо	-	5	1. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр", Яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө"-г боловсруулж, төрийн нарийн бичгийн	80%

					даргын 2025 оны А/85 дугаар тушаалаар батлуулсан. 2. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны ахмадын санг байгуулах, ахмадын санг ажиллуулах тухай журмыг боловсруулж, төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/152, 2025 оны А/153 дугаар тушаалаар батлуулсан. 3. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын шагнал олгох, шагналын сан бүрдүүлэх журмыг боловсруулж Сайдын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/87 дугаар тушаалаар батлуулсан. 4. Цахим хөгжил, инновац харилцаа холбооны яамны гадаад албан томилолтын журам, журмыг дагалдан гарах маягтуудыг боловсруулж Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрээр батлуулах шатанд байна.	
	Зорилт 8. Олон улсын бүсийн, гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлнэ.	Хэрэгжилтийн хувь	-	100	Хэрэгжилтийн хувь-100%	100
31.	Арга хэмжээ 8.1. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2025 оны гадаад айлчлал, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, батлуулна.	Батлагдсан баримт бичиг	-	1	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2025 оны гадаад айлчлал, арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 1 дүгээр сард Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Эхний хагас жилийн хэрэгжилтийг Төрийн нарийн бичгийн даргад танилцуулсан.	100

32	Арга хэмжээ 8.2. Олон улсын байгууллага, гадаад улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулах ажлыг зохион байгуулах, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ.	Бүртгүүлсэн гэрээ хэлэлцээрийн тоо	-	4	Тайлант хугацаанд 5 Харилцан ойлголцлын санамж бичиг, 2 гэрээг айлын талтай эцэслэн тохирч, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулсан. Мөн нийт 7 гэрээ, санамж бичгийг холбогдох журмын дагуу ГХЯ-нд бүртгүүлсэн.	100
33	Арга хэмжээ 8.3. Сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон яамны хэмжээнд албан болон ажлын айлчлал, гадаад томилотыг зохион байгуулна.	Оролцсон арга хэмжээний тоо	-	48	<p>1. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү Бүгд Найрамдах Казакстан Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс, Бүгд Найрамдах Узбекистан Улсад 2025 оны 01 дүгээр сарын 26-аас 02 дугаар сарын 02-ны өдрүүдэд ажлын айлчлал хийхээр төлөвлөж, ГХЯ болон холбогдох Элчин сайдын яамдтай хамтран уг айлчлалын бэлтгэл ажлыг хангаж, зардлын асуудлыг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/189 дугаартай тушаалаар албажуулсан боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан цуцлагдсан.</p> <p>2. Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од Дэлхийн банкны хэрэгжүүлж буй "Ухаалаг засаг-2" төслийн хүрээнд цахим шилжилт, шинэ өндөр технологи судлах, туршлага солилцох хөтөлбөрт оролцооор Бүгд Найрамдах Солонгос Улсад 2025 оны 2 дугаар сарын 9-16-ны өдрүүдэд албан томилолтоор ажилласан.</p> <p>3. Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од АНДСХАБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргыг сонгох тус байгууллагын Онцгой</p>	100

					Удирдах зөвлөлийн хуралд 2025 оны 2 дугаар сарын 20-ны өдөр БНХАУ-ын Бээжин хотноо оролцохоор төлөвлөж, ГХЯ-наас холбогдох санал, бүрэн эрхийг авсан боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж оролцоогүй. 4.ЦХИХХ-ны сайд Ц.Баатархүү Ази, Номхон далайн цахилгаан холбооны байгууллагаас Токио хотноо 2025 оны 5 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд зохион байгуулсан “Ази, Номхон далайн орнуудын мэдээлэл, харилцаа холбооны сайд нарын уулзалт”-д оролцож, Япон Улсад ажлын айлчлал хийхээр төлөвлөн, холбогдох бэлтгэл ажлыг ГХЯ болон Элчин сайдын яамтай хамтран зохион байгуулсан. Мөн сайдын гадаад томилолтын асуудлыг 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, удирдамжийг батлуулсан боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан цуцлагдсан. Тайлант хугацаанд гадаад улс орнуудад зохион байгуулсан 30 арга хэмжээнд яамны 39 албан хаагчийн оролцоход холбогдох дэмжлэгийг үзүүлж ажилласан.	
34	Арга хэмжээ 8.4. Гадаад улс орнуудад зохион байгуулах харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын үзэсгэлэн, экспод төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг оролцуулах ажлыг зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	-	1	КолПро ХХК, Онлайм Нэтворкс ХХК болон ДДиш ХХК-ийн төлөөлөгчид 2025 оны 3 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд Испанийн Хаант Улсын Барселон хотноо зохион байгуулсан “Дэлхийн үүрэн холбооны конгресс (Mobile World Congress)”—т павильон түрээслэн оролцоо хүсэлт ирүүлсний дагуу ГХЯ-нд хүсэлт хүргүүлж 8 төлөөлөгчдийн визний асуудалд дэмжлэг үзүүлж ажилласан.	100

35	<p>Арга хэмжээ 8.5. Олон улсын, бүсийн, гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах ажил зохион байгуулна.</p>	<p>Арга хэмжээний тоо</p>	-	1	<p>Олон улсын, бүсийн, гадаад байгууллагуудтай хамтран ажиллах, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлэх хүрээнд дараах уулзалт, арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>1. Монгол Улсын “Хиймэл оюун, их өгөгдлийн үндэсний стратеги” сэдэвт бага хурлын НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран зохион байгуулсан бөгөөд тус хурлын бэлтгэл ажлын хүрээнд 7 гадаадын илтгэгчдийг угтах, үдэх, байрлах асуудлыг хариуцан зохион байгуулсан.</p> <p>2. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Нгуен Дуан Танийг 1 дүгээр сарын 08-ны өдөр хүлээн авч уулзвав. Уулзалтын үеэр харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд хамтран ажиллах талаар санал солилцов.</p> <p>3. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү 1 дүгээр сарын 15-ны өдөр Бүгд Найрамдах Энэтхэг улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Атул Малхари Готсурвег хүлээн авч уулзвав. Уулзалтын үеэр Монгол Улсын мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг Энэтхэг Улсад мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, хоёр улсын мэдээллийн технологийн компаниудын хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр санал солилцов. Уулзалтын мөрөөр Монгол Улсын Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон БНЭУ-ын Электроник, мэдээллийн</p>	100
----	---	---------------------------	---	---	---	-----

технологийн яам хооронд цахим шилжилт, дижитал шийдлийн чиглэлээр хамтран ажиллах тухай Харилцан ойлголцлын санамж бичгийн төсөлд манай талаас санал тусган 2025 оны 2 дугаар сард хүргүүлсэн. Мөн 3 чиглэлийн хүрээнд сургалт зохион байгуулах талаарх хүсэлтийг манай талаас 2025 оны 3 дугаар сард хүргүүлэв.

4. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од 2025 оны 2 дугаар сарын 26-ны өдөр Бүгд Найрамдах Франц Улсын Сансрыйн агентлаг болон Талес компанийн төлөөллийг хүлээн авч уулзав. Уулзалтын үеэр сансрын тухай хуулийн төсөл боловсруулахад туршлага судлах, гамшгийн үед тандан судалгааны хиймэл дагуулын мэдээ ашиглах, аппли케йшн хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах талаар талууд санал солилцов. Мөн сансрын технологийн чиглэлээр хүний нөөц бэлтгэх, чадавхжуулахад Францын сансар судлалын үндэсний төвтэй 2019 онд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийг шинэчлэн байгуулж, хамтран ажиллахаар тохиролцов.

5. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шэнь Миньжуан болон бусад албаны төлөөлөгчдийг 2025 оны 3 дугаар сарын 12-ны өдөр хүлээн авч уулзав. Уулзалтаар талууд хоёр улсын шинжлэх ухаан, мэдээллийн технологийн салбарт хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах талаар санал солилцов. Мөн цахим худалдааны талбарт Монгол Улсын жижиг дунд үйлдвэрлэл

эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг Alibaba-гаар дамжуулан экспортлох ажлыг эрчимжүүлж, хоёр талын цахим уулзалтыг зохион байгуулах асуудлыг онцлов.

6. Цахим хөгжил, Инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од БНСУ-ЫН Олон улсын хамтын ажиллагааны байгууллага КОЙКА-гийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгч Жу Хэйн Наныг 2025 оны 3 дугаар сарын 25-ны өдөр хүлээн авч уулзав. Уулзалтаар Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн зорилтын хүлээн шинэ болон дагуул хотуудад тулгуурлан AI дата төв байгуулах асуудал дээр хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлэв. Мөн хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр тус байгууллагаас дэмжин ажиллах боломжтой талаар санал солилцов.

7. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү Монгол Улс дахь НҮБ-ын Суурин зохицуулагчаар шинээр томилогдсон Якоб ван Хиердэнийг 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр хүлээн авч уулзаж, хоёр талын хамтын ажиллагааны талаар санал солилцов. Уулзалтын мөрөөр манай зүгээс Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн туршилтын бүсийг Монгол Улсад байгуулах, Төрийн их өгөгдлийн продакшн орчны “DATALAKE” үүсгэхэд шаардагдах дэд бүтэц болон программ хангамжийн төслийн хүрээнд хамтын ажиллагааг эхлүүлэх хүсэлтийг албан ёсоор хүргүүлэв.

8.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Хунгээв Сүгсавадыг 2025 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр хүлээн авч уулзав. Уулзалтын үеэр төрийн үйлчилгээг цахимжуулах чиглэлээр Монгол Улсын сайн туршлагыг тус улстай хуваалцаж, хамтран ажиллах боломжийн талаар санал солилцов. Уулзалтын мөрөөр Монгол Улсын цахим шилжилтийн сайн туршлагыг тус улстай хуваалцаж, хамтын ажиллагааг эхлүүлэхээр тохиролцсоны дагуу төрийн цахим үйлчилгээний И-Монгол платформын танилцуулгыг хүргүүлж, тус мөн тус улсын холбогдох яамтай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах хүсэлтээ илэрхийлэв.

9.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү Япон Улсаас Монгол Улсад Суугаа Элчин Сайд Игавахара Масаруг 2025 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр хүлээн авч уулзав. Уулзалтаар удахгүй болох Японы Эзэн хааны төрийн айлчлалын талаар болон цаашдын хамтын ажиллагааны чиглэлээр дэлгэрэнгүй санал солилцов.

10.Цахим хөгжил, Инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкны Хөрөнгө оруулалт хариуцсан захирал Константин Лимитовский болон бусад албан төлөөллийг 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр хүлээн авч уулзав. Уулзалтаар Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк нь дэд бүтэц, тэр

					дундаа дижитал дэд бүтцийн чиглэлээр хөнгөлөлттэй нөхцөлөөр санхүүжилт хийсэн арвин туршлагатай талаар онцлоод, Монгол Улсын дижитал дэд бүтцийн салбарт хамтран ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлэв.	
36.	Арга хэмжээ 8.6. Салбарын үйл ажиллагааны хүрээнд яамны урилгаар Монгол Улсад ирэх гадаадын төлөөлөгчдийн айлчлалыг зохион байгуулна.	Арга хэмжээний тоо	-	1	<p>Тайлант хугацаанд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урилгаар 1 арга хэмжээнд зочид урьж зохион байгуулав.</p> <p>1. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам болон НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран 2025 оны 2 дугаар сарын 13-ны өдөр “Монгол Улсын их өгөгдөл, хиймэл оюуны стратеги” сэдэвт бага хурлыг зохион байгуулсан. Уг хуралд илтгэгчээр уригдан оролцсон 7 төлөөлөгчийг урих, утхах, үдэх, Монгол Улсад байх хугацааны хөтөлбөрийг харьяа байгууллагуудтай хамтран зохион байгуулав.</p>	100
37	Арга хэмжээ 8.7. Монгол Улсын гишүүнчлэл бүхий олон улсын байгууллагуудын татвар, хураамжийг төлөх бэлтгэл ажлыг хангана.	Арга хэмжээний тоо	-	1	<p>Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/70 дугаартай тушаалаар Гишүүнчлэлийн татвар болон бусад ноогдох зардлыг батлуулсан. Батлагдсан төсвийн хүрээнд холбогдох маягт, нэхэмжлэхийг бэлтгэн СХОХ-ээс 2025 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн гадаад гүйлгээгээр 4 байгууллагын гишүүнчлэлийн татварыг шилжүүлсэн.</p>	100

	Зорилт 9. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлнэ.	Хэрэгжилтийн хувь	-	100	Хэрэгжилтийн хувь-100	85
38.	Арга хэмжээ 9.1. Компанийн засаглалын гэрчилгээ олгох сургалтад хамрагдах.	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	-	1	2025 оны эхний хагас жилийн байдлаар тус сургалт зарлагдаагүй тул үнэлэх боломжгүй.	-
39.	Арга хэмжээ 9.2. Төрийн албаны мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	-	1	Эрхэлсэн түшмэлийн сургалтад Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ш.Батзаяат хамрагдсан. Кибер аюулгүй байдлын бодлого хариуцсан мэргэжилтэн С.Эрдэнэболд Ахлах түшмэлийн багц сургалтад хамрагдсан. Сургалтын үйл ажиллагаа 2025 оны 1 сарын 13-наас - 5 сарын 19-ны хооронд УА дээр явагдсан.	100
40.	Арга хэмжээ 9.3. Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх АЗ сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	-	1	Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтад тус газрын ахлах мэргэжилтэн Б.Тунгалаг, мэргэжилтэн Д.Сэлэнгэ, Салбарын эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Эрдэнэцэцэг нар хамрагдсан. Шалгалтыг 2025 оны 06 дугаар сарын сүүлээр өгөхөөр бүртгүүлсэн.	70
	Зорилт 10. Төрийн албаны чиг үүргийг хэрэгжүүлнэ.	Хэрэгжилтийн хувь	-	100	Хэрэгжилтийн хувь-100%	100

41.	Арга хэмжээ 10.1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг хугацаанд нь бүрэн архивлана.	Архивд хүлээлгэн өгсөн баримт бичгийн тоо	-	1	1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны баримт бичиг архивлан архив бичиг хэрэг хариуцсан мэргэжилтэн М.Мөнхзаяад хүлээлгэн өгөв.	100
42.	Арга хэмжээ 10.2. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдолыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэнэ.	Шийдвэрлэлтийн дундаж хоногийг хугацаагаар	-	-	2025 оны эхний хагас жилийн байдлаар тус газарт өргөдөл, гомдол ирээгүй болно.	-

ХОЁР. НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / Биелэлт	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1.	Үүрэг даалгавар 1.“Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх ерөнхий хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллаж “Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө”-г боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллана.	Боловсруу лсан баримт бичгийн тоо	-	1	Гадаад хэргийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/02 тушаалаар батлагдсан “Ази, Номхон далайн хил дамнасан цаасгүй худалдааг хөнгөвчлөх тухай ерөнхий хэлэлцээр”-н хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж “Үндэсний үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд салбарын онцлог болон цаашид хийгдэх ажлуудад санал тусгаж ажилласан. Мөн НҮБ-ын Ази, Номхон далайн бус нутгийн эдийн засаг, нийгмийн комисс болон Европын худалдааны байгууллага, Гадаад харилцааны яам хамтран 2025 оны 03 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд зохион байгуулсан	01.02- 06.10	100

						"Монголын цахим худалдааны долоо хоног" арга хэмжээнд оролцсон. Тус ажлын хэсгийн хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 15-19-ны өдрүүдэд ажлын хэсгийн гишүүд Дорноговь Замын Үүд, БНХАУ-ын Эрээн хотын хилийн боомтуудад ажиллаж хил дамнасан худалдааг хөнгөвчлөх, цаасгүй мэдээлэл солилцооны бэрхшээлийг газар дээр нь судлах, олон улсын сайн туршлагаас судлах, Мөн цаашид хил гаалийн үйл ажиллагаанд цахим бүрдүүлэлтийг нэвтрүүлэх, мэдээллийн зөрчлийг арилгах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар экспорт, импортын үйл явцыг хялбаршуулах талаар холбогдогч талуудтай санал солилцож ажилласан.		
2.	Үүрэг даалгавар 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн үйл ажиллагааны сонсгол зохион байгуулах.	Арга хэмжээний тоо	-	1	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах дэд зөвлөлийн үйл ажиллагааны сонсгол зохион байгуулах үйл ажиллагааны тайлан болон танилцуулгыг бэлтгэн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн дэд дарга Д.Гэрэлд хүргүүлэв. Сонсгол зохион байгуулах үйл ажиллагаанд харьяа салбарын байгууллагуудын удирдах албан тушаалтнууд болон ГБХНХЯ, ХБХХЕГ, ХБХЭХЗ-ийн гишүүд, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны тэргүүн, Сонсголын бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын иргэний нийгмийн төлөөлөл, Дохионы хэлний хэлмэрч болон Дэд зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнтэй сонсголыг 2025 оны 01 дүгээр сарын 09-ны өдөр тус яамны хүндэтгэлийн танхимд зохион байгуулав. Сонсголыг mass.mn цахим хуудсаар шууд дамжуулагдсан.	01.02-01.09	100	
3.	Үүрэг даалгавар 3. Харилцаа холбооны	Зохион байгуулса	-	1	1.Авлигатай тэмцэх газраас Харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн	04.10-05.02	100	

сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана.	н уулзалтын тоо			<p>төлөвлөгөөний хэрэгжилттэй холбоотой тодруулга авах хүсэлтийн дагуу АТГ болон ХХЗХ-ны холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр уулзалт зохион байгуулсан. Уг уулзалтын хүрээнд яригдсан асуудалтай холбогдуулан нэмэлт мэдээлэл бэлтгэж, byambadorj@jaac.mn цахим шуудангаар хүргүүлсэн.</p> <p>2.ЦХХХ-ны сайдын 2024 оны A/29 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан “Харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг хангах хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Авлигатай тэмцэх газрын холбогдох албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулж, Яаралтай тусламжийн зориулалттай тусгай дугаар болон Төлбөргүй үйлчилгээний зориулалттай тусгай дугаарлалт (Toll free)-ын ялгаа, зааг болон Олон улсын цахилгаан холбооны байгууллагаас гаргасан зөвлөмж /ITU-T E.161.1/-ийн талаар мэдээлэл өгч, санал солилцов. Уулзалтад тус газрын дарга Ш.Батзаяат, ахлах шинжээч Б.Эрдэнэ, ХХЗХ-ны Зохицуулалтын газрын ЗХХ-ийн дарга А.Уранчимэг, мэргэжилтэн Сувд-Эрдэнэ нар оролцов.</p>	
--	-----------------------	--	--	---	--

ТӨЛӨВЛӨГӨӨГ ҮНЭЛСЭН:

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

.....

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

П.АЛТАН-ОД

..... (ОГНОО)

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

НЭГЖИЙН ДАРГА

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.БАТБИЛЭГ

.....(ОГНОО)

ТАЙЛАГНАСАН:

СТРАТЕГИ, БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



НЭГЖИЙН ДАРГА

Ш.БАТЗАЯАТ

..... (ОГНОО)